

Суралцагчийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хэлтэс
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах, хэрэгжилтийг удирдлага зохион байгуулалтаар хангах	-	Хуулийн төсөл	Хуулийн үзэл баримтлалын төсөл	Нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн байна.		Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүнсний хангамжид хамаарах хэсгийн хэрэгжилтэд ХХААХҮЯ-наас үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүн, саналд үндэслэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлал боловсруулах суурь судалгааг хийсэн. Ерөнхий боловсролын сургуулийн хоол	100%	100%

					үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 1а/1392 дугаартай албан бичгээр ХХААХҮЯ- нд хүргүүлсэн. Уг хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран батална. Үзэл баримтлал нь төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ, зохицуулалт, үр дагавар гэсэн бүтэцтэй бөгөөд дор дурдсан харилцааг		
--	--	--	--	--	--	--	--

						зохицуулахаар тусгасан. Үүнд: 1. Хуулийг Боловсролын ерөнхий хуультай нийцүүлэх, холбогдох төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нэмж тусгах; 2. Хүнсний хангамжийн хүртээмж, тогтвортой байдлыг хангах, хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, түүнд төр, хувийн хэвшил, орон нутгийн оролцоог уялдуулан хангах, орон нутгийн эрх үүргийг нэмэгдүүлэх. Хүнсний хангамжийг төр, хувийн хэвшилтэй хамтран орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулах замаар тухайн орон нутгийн компани, нөхөрлөл, хоршоодын оролцоог хангаж, чанар аюулгүй		
--	--	--	--	--	--	--	--	--

							байдлын шаардлага хангасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хүртээмжтэй, тасралтгүй, тогтвортой үнээр ханган нийлүүлэлтийн нэгдсэн төвийг байгуулах. Хүнсний хангамжийг орон нутгийн онцлогт тохирсон байдлаар хэрэгжүүлэх; 3. Санхүүгийн олон талт эх үүсвэрийг бий болгох, бэхжүүлэх; 4. Хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх; 5. Салбар хоорондын уялдааг зохицуулах тогтолцоог бий болгох, үдийн хоолны хөтөлбөрийг хянах, үнэлэх тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг тусгасан.		
1.1.1	Ерөнхий боловсролын сургуулийн	-	Хуулийн төсөл	Хуулийн үзэл баримтлалын төсөл	Ерөнхий боловсролын сургуулийн	Нэмэлт өөрчлөлт оруулах	Ерөнхий боловсролын сургуулийн хоол	100%	100%

	хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийж, нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулна.				хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийн үнэлгээг хийсэн байна.	хуулийн төслийг боловсруулж, ХХААХҮЯ-д хүргүүлсэн байна.	үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн хүнсний хангамжид хамаарах хэсгийн хэрэгжилтэд ХХААХҮЯ-наас үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүн, саналд үндэслэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах үзэл баримтлал боловсруулах суурь судалгааг хийсэн. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулж, 2024 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн 1а/1392 дугаартай албан бичгээр ХХААХҮЯ- нд хүргүүлсэн. Уг хуулийн нэмэлт өөрчлөлтийн үзэл баримтлалыг Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн сайд,		
--	---	--	--	--	---	---	---	--	--

						Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд хамтран батална. Үзэл баримтлал нь төсөл боловсруулах үндэслэл, хэрэгцээ, шаардлага, хамрах хүрээ, зохицуулалт, үр дагавар гэсэн бүтэцтэй бөгөөд дор дурдсан харилцааг зохицуулахаар тусгасан. Үүнд: 1. Хуулийг Боловсролын ерөнхий хуультай нийцүүлэх, холбогдох төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг нэмж тусгах; 2. Хүнсний хангамжийн хүртээмж, тогтвортой байдлыг хангах, хүнсний нэр төрлийг нэмэгдүүлэх, түүнд төр, хувийн хэвшил, орон нутгийн оролцоог		
--	--	--	--	--	--	---	--	--

						уялдуулан хангах, орон нутгийн эрх үүргийг нэмэгдүүлэх. Хүнсний хангамжийг төр, хувийн хэвшилтэй хамтран орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж байгуулах замаар тухайн орон нутгийн компани, нөхөрлөл, хоршоодын оролцоог хангаж, чанар аюулгүй байдлын шаардлага хангасан хүнсний түүхийг эд, бүтээгдэхүүний хүртээмжтэй, тасралтгүй, тогтвортой үнээр ханган нийлүүлэлтийн нэгдсэн төвийг байгуулах. Хүнсний хангамжийг орон нутгийн онцлогт тохирсон байдлаар хэрэгжүүлэх; 3. Санхүүгийн олон талт эх үүсвэрийг бий болгох, бэхжүүлэх; 4.		
--	--	--	--	--	--	--	--	--

							Хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх; 5. Салбар хоорондын уялдааг зохицуулах тогтолцоог бий болгох, үдийн хоолны хөтөлбөрийг хянах, үнэлэх тогтолцоог бий болгох зэрэг асуудлыг тусгасан. Хавсралт: 2 файл		
1.1.2	Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлуулна.	-	Төлөвлөгөө, Засгийн газрын тогтоолын төсөл	Засгийн газрын 2020 оны 207, 2021 оны 18 дугаар тогтоол	Холбогдох тооцоо судалгаа хийж, аймаг, орон нутаг, нийслэлийн түвшинд бодлогын шийдэл хувилбар боловсруулан дунд хугацааны төлөвлөгөөний төсөл боловсруулна.	Төлөвлөгөөний төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн байна.	НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх, хэрэгжүүлэх бодлогын шийдэл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын даалгаврыг боловсруулсан. Уг зөвлөх үйлчилгээний хүрээнд	70%	70%

						сургуулийн суурь судалгааг шинэчлэн боловсруулах, хоолны зардал дахь хүнсний бүтээгдэхүүний эзлэх хэмжээг тодорхойлох, хоол хүнсний хангамжийг бүс, аймаг, сумын түвшинд зохион байгуулах хувилбарт шийдэл, хүний нөөц, хоол үйлдвэрлэлийн байрын төлөвлөлт, санхүүжилтийн олон талт хувилбарын шийдэл боловсруулах бодлогын судалгааг хамтран хийж байна. Уг судалгаанд үндэслэн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахаар ажиллаж байна. Дээрх зөвлөх үйлчилгээний хүрээнд нийслэлийн төрийн		
--	--	--	--	--	--	--	--	--

						өмчийн сургуульд MNS 7005:2023 Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлагын гарааны үнэлгээг эхлүүлсэн. Орон нутгийн үнэлгээг 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулна. Үнэлгээний дүнд үндэслэн төлөвлөгөөг нарийвчлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулна. 2023- 2024 оны статистик мэдээгээр төрийн өмчийн 695 сургуулийн 246 нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдсан байна. Харин 649 сургууль нь хоолны газартай байгаа бөгөөд тэдгээрийн 28 хувь нь 2-4 хоолны газартай байна. Хоолны		
--	--	--	--	--	--	---	--	--

						газартай сургуулийн 323 нь MNS7005:2023 стандартын шаардлагыг хангасан байна.		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ								
3.1.	Сургуулийн өмнөх, ерөнхий болон тэгш хамран сургах боловсролын хөгжлийн чиглэлээр батлагдсан бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн удирдлага, зохицуулалтыг хангах чиглэлээр дүрэм, журам, удирдамж, аргачлал, зөвлөмж боловсруулах, төслийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, хэрэгжилтэд хяналт- шинжилгээ хийх, эрх зүйн	Улс, орон нутгийн төсөв, эцэг эх, асран хамгаалагч	Аргачлал батлах тухай Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал, Засгийн газрын хуралдаанд танилцуулна.	Засгийн газрын 2019 оны 450, 2021 оны 207 дугаар тогтоол, 2022 оны 36, 55 дугаар тэмдэглэл, 2022 оны 498 дугаар тогтоол	Хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх, зарцуулах аргачлалыг батлуулсан байна. Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, хангамж, хүртээмжийг сайжруулах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан байна.	Хүүхдийн хоолны зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэх тооцооллыг боловсруулсан. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөг, 24 цагийн ажиллагаатай, сувилал, асрамжийн болон тусгай цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 3600 төгрөгөөр тогтоосныг мөрдөж байгаа бөгөөд уг зардлыг	90%	90%

	баримт бичгийн төсөл боловсруулах, батлуулах					Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд боломжит эх үүсвэрээс санхүүжүүлэхээр “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Үүнд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 2024.09.01-ний өдрөөс эхлэн 525 төгрөгөөр нэмэгдүүлэн 3000 төгрөг, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг, цэцэрлэгийн бүлгийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 500 төгрөгөөр		
--	---	--	--	--	--	---	--	--

						нэмэгдүүлж, 4100 төгрөг болгоход 11.8 тэрбум төгрөг шаардагдана. Хоолны зардлыг 500 төгрөгөөр нэмэгдүүлснээр хоол, хүнсээр авах шаардлагатай илчлэгийн 60.4 хувийг хангах боломжтой болно. Тогтоолын төсөлд яамдаас санал авч, саналыг нэгтгэн ЗГ-ын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2024.05.29-ний өдрийн 237 дугаар тогтоолоор баталсан. Мөн орон нутаг, эцэг эхийн оролцоо дэмжлэгээр хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, Сүү хөтөлбөрийг дунд болон ахлах ангиудад хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал: Дундговь, Орхон аймаг, нийслэлд сургууль цэцэрлэгийн 30.0 мянган хүүхдэд 7 хоногийн 3 өдөр		
--	--	--	--	--	--	---	--	--

							сүү өгч эхэлсэн, Өмнөговь аймаг дунд ангийн сурагчдыг Үдийн хоолонд хамруулж, цэцэрлэгийн хоолны зардлыг 1200, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2900, Орхон аймаг үдийн хоолны зардлыг 1300 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх, зарцуулах аргачлал, Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан.		
3.1.1	Хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагчаас төвлөрүүлэх, зарцуулах аргачлалыг батлуулсан байна.	-	Боловсрол, шинжлэх ухааны сайдын тушаал	Болоовсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/59 дүгээр тушаал	Аргачлалыг боловсруулж, батлуулсан байна.	-	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс төвлөрүүлэх, зарцуулах аргачлалын төслийг боловсруулсан. Аргачлалын төсөлд	90%	90%

						Өвөрхангай, Дорнод, Говь- Алтай, Сүхбаатар, Увс аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар, цэцэрлэг, нийслэлийн Сүхбаатар, Баянгол дүүргийн Боловсролын хэлтэс, цэцэрлэгээс түүврийн аргаар санал авч, ирүүлсэн саналыг тусган сайжруулж, 2024 оны 3 дугаар сард Боловсролын ерөнхий газар, нийслэлийн төвийн 5 дүүргийн 10 цэцэрлэгийн эрхлэгчийг хамруулан хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлгээс гарсан саналыг аргачлалын төсөлд тусган холбогдох газар, хэлтсийн удирдлагад танилцуулж байна. Аргачлалын төслийг боловсруулахдаа байгууллагад нэмэлт данс нээхгүй, үндсэн		
--	--	--	--	--	--	--	--	--

						дансанд хоолны зардлыг төвлөрүүлэх, өдрийн ирцийг боловсролын мэдээллийн нэгдсэн сангаар дамжуулан бүртгэх, мэдээлэх, тайлагнах, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон багш ирцийн бүртгэл мэдээллийг баталгаажуулах, санхүү хариуцсан албан тушаалтан эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон багшид мэдээллийг нээлттэй өгч, цэцэрлэг болон хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт чирэгдэл, хүндрэл үүсгэхгүй байхаар тооцон, 3 бүлэг, 18 заалттайгаар боловсруулсан. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 2024 оны батлагдсан төсөвт багтаан		
--	--	--	--	--	--	---	--	--

							нэмэгдүүлэх асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 2024.05.29-ний өдрийн 237 дугаар тогтоолоор хүүхдийн хоолны зардлыг 3000 төгрөг болгон нэмэгдүүлж, баталсан. Цаашид эцэг эхийн хариуцах хувь хэмжээг тогтоох асуудлыг Засгийн газарт хүргүүлэн шийдвэрлүүлсний үндсэн дээр аргачлалыг батлан хэрэгжүүлнэ. Хавсралт: 2 файл		
3.1.2	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх хувилбарыг Засгийн газарт танилцуулна.	-	Хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх хувилбар, танилцуулга	Засгийн газрын 2019 оны 450, 2021 оны 207 дугаар тогтоол, 2022 оны 36, 55 дугаар тэмдэглэл, 2022 оны 498 дугаар тогтоол	Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, зардлын эцэг эх, асран хамгаалагч хариуцах хувь хэмжээний судалгаа, тооцооллыг боловсруулсан байна.	Хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх хувилбарт саналыг Засгийн газрын хуралдаанаар танилцуулсан байна.	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүүхдийн хоолны зардлын нормативыг нэмэгдүүлэх, төр болон эцэг эх хамтран хариуцах хувь хэмжээний хувилбарыг /төр 100%, төр эцэг эх	100%	100%

							50/50 хувиар, 70/30 хувиар хариуцах/ боловсруулсан. Хүүхдийн хоолны зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэх тооцооллыг боловсруулсан. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоолоор 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 2475 төгрөг, 24 цагийн ажиллагаатай, сувилал, асрамжийн болон тусгай цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлыг 3600 төгрөгөөр тогтоосныг мөрдөж байгаа бөгөөд уг зардлыг Боловсрол, шинжлэх ухааны сайдын багцын 2024 оны батлагдсан төсвийн хүрээнд		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						боломжит эх үүсвэрээс санхүүжүүлэхээр “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулсан. Үүнд төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 2024.09.01-ний өдрөөс эхлэн 525 төгрөгөөр нэмэгдүүлэн 3000 төгрөг, уртасгасан цагаар ажиллах цэцэрлэг, цэцэрлэгийн бүлгийн хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нэг өдрийн хоолны зардлыг 500 төгрөгөөр нэмэгдүүлж, 4100 төгрөг болгоход 11.8 тэрбум төгрөг шаардагдана. Хоолны зардлыг 500 төгрөгөөр		
--	--	--	--	--	--	--	--	--

						нэмэгдүүлснээр хоол, хүнсээр авах шаардлагатай илчлэгийн 60.4 хувийг хангах боломжтой болно. Тогтоолын төсөлд яамдаас санал авч, саналыг нэгтгэн ЗГ- ын хуралдаанд танилцуулж, Засгийн газрын 2024.05.29-ний өдрийн 237 дугаар тогтоолоор баталсан. Мөн орон нутаг, эцэг эхийн оролцоо дэмжлэгээр хүүхдийн хоолны зардлыг нэмэгдүүлэх, Сүү хөтөлбөрийг дунд болон ахлах ангиудад хэрэгжүүлж эхлээд байна. Тухайлбал: Дундговь, Орхон аймаг, нийслэлд сургууль цэцэрлэгийн 30.0 мянган хүүхдэд 7 хоногийн 3 өдөр сүү өгч эхэлсэн, Өмнөговь аймаг дунд ангийн сурагчдыг Үдийн хоолонд хамруулж, цэцэрлэгийн		
--	--	--	--	--	--	--	--	--

							хоолны зардлыг 1200, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 2900, Орхон аймаг үдийн хоолны зардлыг 1300 төгрөгөөр нэмэгдүүлсэн. Хавсралт: 6 файл		
3.1.3	Үдийн хоолны өртөгт суурилсан санхүүжилтийн хувилбарыг боловсруулж, хэрэгжүүлнэ.	Улсын төсөв	БШУ-ын сайдын тушаал, аргачлал	Судалгааны тайлан	Өртөгт суурилсан санхүүжилтийг хэрэгжүүлэх аргачлал, хяналт үнэлгээний төлөвлөгөөг батлуулан төсөв санхүүжилтийг шийдвэрлэсэн байна.	Өртөгт суурилсан санхүүжилтийн хувилбарыг 50 хүртэлх сургуульд туршина.	Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн суралцагчийн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан байдлаар шийдвэрлэх боломжийн судалгааг БСҮХ-тай хамтран Орхон аймагт зохион байгуулсан. Энэхүү судалгаанд Орхон аймгийн төрийн өмчийн 15 сургуулийн ус, цахилгааны 5 өдрийн хэрэглээ, тоног төхөөрөмж, засвар үйлчилгээнд сүүлийн 2 жилд зарцуулсан зардал, ажилчдын	100%	100%

						цалин хөлс, ариутгал халдваргүйтгэлийн зардлыг судлан үзэж, ҮДИЙН ХООЛНЫ ӨРТГИЙН 8 ХУВЬСАГЧИЙГ гаргасан. Үүнд: 1. Суурь хувьсах зардалд: а) гал тогооны ажилчдын үндсэн цалин, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл 46,5%, б) гал тогооны ажилтны нэмэгдэл, нэмэгдэл хөлс, түүнд ногдох нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл 19,9%, 2. Бусад хувьсах зардалд: а) Гал тогооны ариутгал, үйлчилгээ, аюулгүй байдлын зардал зардал 2,9%, б) Ажилчдын сургалтын зардал 0,9%, в) Эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын үйлчилгээний зардал 0,5%, г) Ус,		
--	--	--	--	--	--	--	--	--

						цахилгаан болон эрчим хүчний зардал 12,8%, д) Засварын зардал 3,2%, 3.Нөхөн хангалтын хувьсах зардал: а) Гал тогооны тоног төхөөрөмж, хэрэгслийн нөхөн хангалтын зардал14,6%, нийт 100% байна. Төрөөс хариуцах зардлын хувь хэмжээ 66,5%, үүсгэн байгуулагчийн хариуцах зардлын хувь 33,5% байна. Мөн хүүхдийн тооны итгэлцүүрийг 0,36-2,70 байхаар тооцон гаргасан. Энэхүү тооцоо судалгаанд үндэслэн үдийн хоолны зардлыг өртөгт суурилсан санхүүжилтэд шилжүүлэх талаарх Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулсан. Хавсралт: 3 файл		
--	--	--	--	--	--	--	--	--

3.1.4	Хүүхдийн хоол үйлдвэрлэл, хүнсний хангамжид үйлдвэрийн аргаар бэлтгэсэн хүнс, хоолны бэлдэц нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагыг татвар, урамшууллын бодлогоор дэмжих эрх зүйн орчныг бүрдүүлэх санал боловсруулах	Улсын төсөв	Эрх зүйн санал, төсөл	-	Судалгаа тооцооллыг боловсруулж, үр дагаврын шинжилгээг хийсэн байна.	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай, Хүнсний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал боловсруулж, ХХААХҮЯ-нд хүргүүлсэн байна.	Хүүхдийн хоол хүнсний хангамжийг сайжруулах, үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнс, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээгээр худалдан авах арга хэмжээг 2023 оноос эхлэн хэрэгжүүлсэн. 2024 оны 5 сарын байдлаар Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт 31 нэр төрлийн хүнс, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг нийлүүлж, давхардсан тоогоор 396 сургууль бүтээгдэхүүн захиалж худалдан авалт хийсэн байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд хэрэглэх хүнсний хэрэгцээний судалгааг “Монгол	90%	90%
-------	--	-------------	-----------------------	---	---	---	---	-----	-----

						Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын дагуу Баруун, Хангайн, Төвийн, Зүүн бүс, Улаанбаатар хотоор ангилан хүнсний 6 бүлгээр, бүс тус бүрээр боловсрууллаа. Тухайлбал, махны хувьд улсын хэмжээнд хоногт 70 тонн, сард 1,529 тонн, нэг хичээлийн жилд 12,6 мянган тонн шаардагдах тооцоотой байна. Мөн ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд хийсэн “Бага ангийн сурагчдын хоол тэжээлийн байдал”-д хийсэн судалгаагаар судалгаанд хамрагдсан сурагчдын 74% нь ясны сийрэгжилттэй, 26% нь зөөлөн эдийн зөөлрөлтэй, сурагчдын өдөрт		
--	--	--	--	--	--	---	--	--

						хэрэглэж байгаа сүү, сүүн бүтээгдэхүүний хэмжээ нь авах шаардлагатай зөвлөмж хэмжээнээс 3.4 дахин бага дүнтэй гарсан. Сургууль, цэцэрлэгийн хүүхдэд өдөрт 1 аяга сүү уулгаснаар кальци, Д амин дэмийн дутлыг нөхөх, ясны сийрэгжилтийг бууруулах, дархлааг сайжруулж, өсөлт хөгжлийг дэмжих бөгөөд Боловсрол, шинжлэх ухааны сайдын аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан 2024 оны гэрээнд “Сүү” хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээг тусгасан. Энэ хүрээнд Дундговь, Орхон аймаг, нийслэлд сургууль цэцэрлэгийн 30 гаруй мянган хүүхдэд 7 хоногийн 3 өдөр сүү өгч эхлээд байна.		
--	--	--	--	--	--	---	--	--

							Дээрх арга хэмжээг улсын хэмжээнд өргөжүүлэх хэрэгцээний судалгаа тооцооллыг боловсруулсан. Мөн Хүнсний тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлд үйлдвэрийн аргаар боловсруулсан хүнс нийлүүлсэн аж ахуйн нэгжийг татвар, урамшууллын бодлогоор дэмжих, дэмжлэг үзүүлэх саналыг хүргүүлсэн. Хавсралт: 1 файл		
3.1.5	"Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7005:2023 стандартын түвшинг	Улсын төсөв, ОУБ	Стандартын шаардлага хангасан сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь	2023 онд 60.8 хувь	Стандартыг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулна. Стандартын үнэлгээ хийх удирдамж, үнэлгээний хуудсыг боловсруулан, хэрэгжүүлнэ.	Стандартын түвшинг 70 хувьд хүргэх, зарим сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрыг нэгтгэн зохион байгуулах төлөвлөлт, үр ашгийг тооцон Засгийн газрын	"Ерөнхий боловсролын сургууль, дотуур байр, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7005:2023 стандартын үнэлгээний хуудсыг боловсруулж, НҮБ-ын ХХААБ-тай	70%	70%

	тодорхойлох үнэлгээг зохион байгуулж, стандартын түвшинг дээшлүүлэх, зарим сургуулийн хоол үйлдвэрлэлийн газрыг нэгтгэн зохион байгуулах төлөвлөлт, үр ашгийг тооцон Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.					хуралдаанаар хэлэлцүүлнэ.	хамтран стандартын үнэлгээг хийхээр зөвлөх үйлчилгээний санхүүжилтийг шийдвэрлүүлж, үнэлгээг хийж эхлээд байна. Үнэлгээнд үндэслэн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах менежментийг хэрэгжүүлж үр дүнг тооцон цаашид түгээн дэлгэрүүлэх загварыг бий болгоно. Үнэлгээний дүн 10 сард гарна. Жайка олон улсын байгууллагын төслийн 2 дугаар шатыг хэрэгжүүлэх хүрээнд дундын гал тогоо байгуулах хувилбарыг боловсруулан төслийг хэлэлцүүлж байна. Мөн нийслэлийн сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг		
--	--	--	--	--	--	--------------------------------------	--	--	--

							сайжруулах, стандартад нийцүүлэх, хүнсний хангамжийн асуудлыг НИТХ-наар танилцуулж, тэмдэглэл гарсан. Нийслэлийн сургуулийн хоолны газрыг стандартын шаардлага хангуулах чиглэлээр 3.5 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт суулгасан. КОЙКА, GPE байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд нийслэлд 10 сургуульд жишиг гал тогоо байгуулж, 45 сургуульд хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг зарлаад байна.		
3.1.6	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургууль дотор шаардлага хангасан ундны цэвэр усаар	Улсын төсөв, ОУБ	Ундны цэвэр усаар хангагдсан сургуулийн эзлэх хувь	2023 онд 57.7 хувь	Нийт сургуулийн 70 хувийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангасан байна.	Нийт сургуулийг шүүлтүүртэй ундны цэвэр усаар хангасан байна.	2023-2024 оны статистик мэдээгээр нийт сургуулийн 72,9% нь ус цэвэршүүлэгч төхөөрөмжөөр хангагдсан бөгөөд ус цэвэршүүлэгч	50%	50%

	хангах нөхцөлийг бүрдүүлнэ.						төхөөрөмжөөр хангагдсан сургуульд 72 хүүхдийн дунд нэг ус цэвэршүүлэгч төхөөрөмж ноогдож байна. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 6782:2019 стандартын 6.6.6-д зориулалтын ус цэвэршүүлэх төхөөрөмжийг 75 хүртэлх хүүхдийн дунд нэг байхаар тооцож давхар бүрт байршуулна гэж заасан. Шаардлагатай ус цэвэршүүлэгчийн тооцооллыг гарган СХОГ-т хүргүүлж, БШУ-ы сайдын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн "Төлөвлөгөө баталж, эрх шилжүүлэх тухай" А/590 дүгээр тушаалаар Боловсрол, шинжлэх ухааны салбарын 2024		
--	-----------------------------------	--	--	--	--	--	---	--	--

							оны бараа худалдан авах төлөвлөгөөнд сургуулийн гал тогооны тоног төхөөрөмжид 1,5 тэрбум төгрөг баталсан, ус цэвэршүүлэгч тоног төхөөрөмжийг тусгайлан заагаагүй байна. Иймд НҮБ-ын Хүүхдийн сангийн 2025 оны ажлын төлөвлөгөөнд шаардлагатай тооцоо судалгаа, санхүүжилтийн саналыг хүргүүлээд байна. Урьдчилсан байдлаар НҮБ-ын Хүүхдийн сан болон орон нутгийн төсвөөс 80.7 сая төгрөгийн ус цэвэршүүлэгч төхөөрөмжийг Дундговь, Дархан, Өвөрхангай, Төв, Ховд аймгуудын сургуулиудад олгосон		
3.1.7	Боловсролын сургалтын байгууллагын	-	Хүний нөөцийн нормативын	Ажил мэргэжлийн	Боловсролын сургалтын байгууллагын	-	Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн	70%	70%

	хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийн норматив, ажил мэргэжлийн стандартыг боловсруулж батлуулна.		тушаалын төсөл, ажил мэргэжлийн стандарт	стандартын төсөл	хоол үйлдвэрлэлийн хүний нөөцийн норматив, ажил мэргэжлийн стандартыг боловсруулж батлуулсан байна.		сайдын "Орон тооны хязгаарын жишиг норматив батлах тухай" 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн А/85/34 дугаар хамтарсан тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн хүүхдийн цэцэрлэгийн багш, ажилтны орон тооны хязгаарыг жишиг нормативыг баталсан. Үүнд: 3-4 бүлэгтэй цэцэрлэгт 1 тогооч, 3-11 хүртэл бүлэгтэй цэцэрлэгт 1 гал тогооны туслах ажилтан, 5-17 ба түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгт 2 тогооч, 12-17 ба түүнээс дээш бүлэгтэй цэцэрлэгт 2-3 гал тогооны туслах ажилтан ажиллахаар баталсан байна. Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага,		
--	---	--	---	---------------------	---	--	--	--	--

						ажилтны орон тооны жишиг хязгаарыг Боловсрол, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлахаар тогтсон. Энэхүү нормативд 101-ээс дээш хүүхэдтэй сургууль бүрд 1 хоол зүйч, 100 хүртэлх болон 101-300 хүртэлх хүүхэдтэй сургуульд 1 тогооч, 301-ээс дээш бол 2-6 хүртэлх тогооч, 1-3 хүртэлх гал тогооны туслах ажиллахаар тооцон санал хүргүүлсэн. Дээрх 2 яамны ярилцан тохирсон хувилбарт 301-ээс дээш хүүхэдтэй сургууль бүрд 1 хоол зүйч, 300 хүртэл суралцагчтай бага сургуульд 1 тогооч, 301-1200 суралцагчтай бага сургуульд 2 хүртэл тогооч, 1201-ээс дээш суралцагчтай бага сургуульд 500		
--	--	--	--	--	--	--	--	--

							хүүхэд тутамд 1 тогоочийг хувьсах зардлаар тооцож, олгосон төсөвт багтаан ажиллуулахаар тогтсон байна. Хавсралт: 2 файл		
3.1.8	Хоол үйлдвэрлэлийн ажилчдын ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр Бүсийн сургагч багшийг бэлтгэнэ.	НҮБ-ын Хүүхдийн сан	Бэлтгэгдсэн сургагч багшийн тоо	-	Сургагч багшийг бэлтгэсэн байна.	-	КОЙКА олон улсын байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төслийн хүрээнд “Хүүхдийн хоол үйлдвэрлэл, шим тэжээлийн сургалт, арга зүйн үндэсний төв”-ийг Монгол Улсын Шинжлэх ухаан технологийн их сургуулийг түшиглэн байгуулахаар төлөвлөсөн. Уг асуудлыг Засгийн газрын 2024 оны 04 дүгээр сарын 10-ны	70%	70%

						өдрийн хуралдаанд танилцуулж, 14 дүгээр тэмдэглэл гарсан. Дээрх төвийн үйл ажиллагааг 2024 оны 9 дүгээр сард нээхээр төлөвлөн ажиллаж байна. Энэхүү төвөөр дамжуулан танхим болон цахимаар Бүсийн сургагч багшийг бэлтгэнэ. Мөн дээрх төслийн хүрээнд "Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний сургагч багш" бэлтгэх сургалтыг зохион байгуулсан. Сургалтад боловсрол, хүнс, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн төрийн байгууллагын холбогдох удирдлага, мэргэжилтэн зэрэг нийт 30 гаруй хүн хамрагдсан. Сургалтаар БНСУ-аас ирсэн хүүхдийн хоол, шим		
--	--	--	--	--	--	--	--	--

							тэжээлийн мэргэжлийн багш нар 6 өдрийн 30 цагийн хичээлийг заасан. Хавсралт: 1 файл		
--	--	--	--	--	--	--	--	--	--

Үнэлсэн:

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)

Тайлагнасан:

..... /...../

(албан тушаал)

(гарын үсэг)

.....

(огноо)